



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/02-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 7036-3040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 7036-3036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: О.Анхбаяр  
Утас: 7036-2442 Цахим хаяг: [ankhbayaro@audit.gov.mn](mailto:ankhbayaro@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Дотоод хяналт.....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
4.4 Материаллаг байдал .....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
8. Аудитын илрүүлэлт .....	15
8.1 Албан шаардлага .....	16
8.2 Зөвлөмж .....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/02-НА-СТА-ОНА

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Сэлэнгэ үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал:**

1. Мөнгөн гүйлгээний тайлангаар 2021 онд нийт 32,445.3 мянган төгрөгийн мөнгөн орлого, 30,646.7 мянган төгрөгийн мөнгөн зарлага, үүнээс кассаар буюу бэлэн мөнгөөр 14,295.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн болон бусад хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөний дийлэнхийг даргын үүрэг гүйцэтгэгч Ц. Алтанцэцэг гүйцэтгэж, хөрөнгийг захиран зарцуулснаар хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналт алдагдсан,

СЭА-2022/02-НА-СТА-ОНА

018020369

2. Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй,
3. Журнал, кассын тайлан, бараа материалын тайлан, шаардах хуудас, зарлагын баримт зэрэг анхан шатны баримтуудыг нягтлан бодогчоор хянуулдаггүй, тамга, тэмдгээр баталгаажуулдаггүй бөгөөд тайлант онд бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **2,479.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг хийж, бүртгэл тайланд тусгасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө. 4.1.1: Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1: Анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2: Журналд бичих, 14.3.3: Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4: Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5: Санхүүгийн тайлан гаргах”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	1,798,602.20
1.1.2	Дансны авлага	1,185,500.00	1,185,500.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	61,800.00
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	300,000.00	150,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө /мал/	24,172,000.00	26,543,500.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>25,657,500.00</b>	<b>29,739,402.20</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,316,737.48	28,316,737.48
1.2.2	Биет бус хөрөнгө	36,780,000.00	36,780,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>65,096,737.48</b>	<b>61,041,745.99</b>
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>90,754,237.48</b>	<b>90,781,148.19</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	450,000.00	450,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	5,707,590.00	5,261,445.00
2.1.1.3	Татварын өр	397,585.00	981,000.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	4,273,012.80	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,828,187.80</b>	<b>6,692,445.00</b>
2.1.2	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>10,828,187.80</b>	<b>6,692,445.00</b>
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.3	<b>Өмч</b>	41,615,000.00	41,615,000.00
2.3.1	-төрийн	41,615,000.00	41,615,000.00
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,776,074.48	10,776,074.48
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,780,000.00	36,780,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(9,245,024.80)	(5,082,371.29)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>79,926,049.68</b>	<b>84,088,703.19</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>90,754,237.48</b>	<b>90,781,148.19</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	24,529,650.00	26,572,595.00
2	Борлуулалтын өртөг	21,136,592.70	23,584,500.00
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>3,393,057.30</b>	<b>2,988,095.00</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	7,535,000.00	13,428,250.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	17,685,028.80	12,066,191.50
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	403,547.80	187,500.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(7,160,519.30)</b>	<b>(4,162,653.50)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(7,160,519.30)</b>	<b>(4,162,653.50)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(7,160,519.30)</b>	<b>(4,162,653.50)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(7,160,519.30)</b>	<b>(4,162,653.50)</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>41,615,000.00</b>	<b>10,776,074.48</b>	<b>36,780,000.00</b>	<b>(2,084,505.50)</b>	<b>87,086,568.98</b>
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>41,615,000.00</b>	<b>10,776,074.48</b>	<b>36,780,000.00</b>	<b>(2,084,505.50)</b>	<b>87,086,568.98</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(7,160,519.30)	(7,160,519.30)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>41,615,000.00</b>	<b>10,776,074.48</b>	<b>36,780,000.00</b>	<b>(9,245,024.80)</b>	<b>79,926,049.68</b>
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(7,555,500.00)	(7,555,500.00)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>41,615,000.00</b>	<b>10,776,074.48</b>	<b>36,780,000.00</b>	<b>(5,082,371.29)</b>	<b>84,088,703.18</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>24,529,650.00</b>	<b>32,445,345.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	24,529,650.00	26,572,595.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	5,872,750.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>25,777,690.00</b>	<b>30,646,742.80</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	15,152,695.00	16,253,005.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,900,000.00	8,783,512.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,032,500.00	2,225,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,058,600.00	1,574,430.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,070,035.00	519,725.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,563,860.00	1,291,070.00
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,248,040.00)</b>	<b>1,798,602.20</b>
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,248,040.00)</b>	<b>1,798,602.20</b>
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,248,040.00</b>	-
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	-	<b>1,798,602.20</b>

## 2.4 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>					
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	төгрөг	<b>32,064,650.0</b>	<b>40,000,845.0</b>	<b>7,936,195.0</b>	<b>24.8%</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	24,529,650.0	26,572,595.0	2,042,945.0	8.3%
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	төгрөг	<b>39,225,169.3</b>	<b>35,838,191.5</b>	<b>3,386,977.8</b>	<b>(8.6%)</b>
	Үүнээс:	төгрөг	<b>39,225,169.3</b>	35,838,191.5	3,386,977.8	(8.6%)
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	төгрөг	21,136,592.7	23,584,500.0	2,447,907.3	11.5%
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	төгрөг	18,088,576.6	12,253,691.5	(5,834,885.1)	(32.3%)
	в) Хөрөнгө оруулалт их засвар	төгрөг			-	-
<b>4</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	төгрөг	<b>(7,160.519.3)</b>	<b>4,162,653.5</b>	<b>11,323,172.8</b>	<b>372.0%</b>

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн аж ахуйн нэгж, иргэд байгууллагыг цэвэр үүлдрийн мал амьтдаар хангах,
- Цэвэр үүлдрийн мал амьтдын үр, үр хөврөл импортлох,
- Шилдэг малыг экспортлох,
- Цэвэр үүлдэр, түүний эрлийз малыг шилэн сонгох замаар шилдэг хээлтэгч, хээлтүүлэгч өсгөн бойжуулах,
- Аж ахуйн нэгж, иргэд байгууллагын малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж малын үүлдэрлэг байдал ашиг шимийг сайжруулах,
- Аж ахуйн нэгж, иргэд байгууллагыг холбогдох мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Шинэ техник технологи нэвтрүүлэх,
- Цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалан бататгах

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2005 оны 6 дугаар 28-ны өдрийн 51 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл “*Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх*”, 19.1 дэх “*Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “*Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих*” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай,

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,798.6	1,798.6
Авлага	1,185.5	1,247.3	61.8
Бараа материал	300.0	150.0	(150.0)
Бусад эргэлтийн хөрөнгө /мал/	24,172.0	26,543.5	2,317.5
Үндсэн хөрөнгө	28,316.7	24,261.7	(4,055)
Биет бус хөрөнгө	36,780.0	36,780.0	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>90,754.2</b>	<b>90,781.1</b>	<b>26.9</b>
Өр төлбөр	10,828.1	6,692.4	(4,135.7)
Эздийн өмч	41,615.0	41,615.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	36,780.0	36,780.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,776.1	10,776.1	-
Хуримтлагдсан ашиг	(9,245.0)	(5,082.4)	4,162.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>90,754.2</b>	<b>90,781.1</b>	<b>26.9</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө данс 1,798.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайлант оны орлогын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,692.4 мянган төгрөг болж, 4,135.7 мянган төгрөгөөр буурсан нь малын хөлийн татварын өглөг 583.4 мянган төгрөгөөр өссөн болон цалингийн өглөг 446.1 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 4,273.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл (5,082.4) мянган төгрөг болж 4,162.6 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн ашиг нөлөөлсөн байна.

### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-нь 2021 оны орлого, зарлагын төлөвлөгөөг холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Гүйцэтгэлээр 40,000.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 35,838.2 мянган төгрөгийн зардал гарган 4,162.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Дотоод хяналт**

Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд ТЕЗ-ийн зүгээс болон үйлдвэрийн газрын удирдлагын зүгээс дотоод хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг холбогдох байгууллагад танилцуулж, үнэлэлт дүгнэлт хийгдээгүй байна.

##### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт зарлагын 35,838.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 358.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **250.9** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### 5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын мэдээлбэл зохих 18 төрлийн 148 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, **52** мэдээллийг хугацаа хоцроон, **44** мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тогтоосон хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх

##### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин

төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасны дагуу техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг тооцоогүй санхүүгийн төлөвлөгөөг батлуулаагүй бөгөөд шагнал урамшуулал олгох, зочин төлөөлөгч хүлээн авах зардал гараагүй байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 16,542.7 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг биелүүлж, 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	16,542.7	1	16,542.7	50.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>16,542.7</b>	<b>2</b>	<b>16,542.7</b>	<b>66.6</b>

/мянган төгрөг/

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

**7.1** Тус газрын захирлыг 2020 оны 07-р сарын 31-ны өдөр чөлөөлсөн боловч жил гаруй хугацаа өнгөрөхөд дахин томилоогүйгээс захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч / тус газрын орон тооны мал зүйч хавсран / удирдаж байна.

**7.2** Тус үйлдвэрийн газрын захирлын 2017 оны 09 дүгээр тушаалаар иргэн Д.Гийриймааг нягтлан бодогчоор томилж, санхүүгийн тайлан гаргасан улирал бүр 100.0 мянган төгрөгийн урамшуулал олгож байхаар шийдвэрлэсэн бөгөөд Д.Гийриймаа нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэггүй, эд хариуцагч ажиллуулдаггүй байна.

**7.3** “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ -ын өөрийн бүртгэлээр 2021 оны эцэст нийт 1,216 толгой мал тоологдож бүртгэл тайланд тусгасан боловч мал, тэжээвэр амьтад, худгийн 2021 оны тооллогын “А” дансаар 1,118 толгой мал буюу 98 толгой мал дутуу тоологдсон байна. Тус байгууллагаас уг зөрүү нь хээлтүүлгийн зориулалтаар айл, өрхүүдэд тараан байршуулсан хуцыг Ковид-19 өвчний улмаас жилийн эцэст буцаан татаж чадаагүй тул тооллогоор тухайн айл, өрхүүдийн малын тоонд тоологдсоноос шалтгаалан зөрүү үүсэн гэж тайлбар өгсөн. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан уг зөрүүг тулган баталгаажуулаагүй учир дараагийн аудитаар эргэлтийн хөрөнгийн (мал) үлдэгдлийг бодитоор оршин байгаа эсэхийг тулган баталгаажуулах нь зүйтэй юм.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **5,785.8** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,479.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,306.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

## 8.1 Албан шаардлага

1. “Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ -ын 2021 оны зорилтот түвшин, төлөвлөгөөг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зардлын тооцоогоор нэг бүрчлэн төлөвлөөгүй, бүтэц, орон тоог тодорхойлж, мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь *“Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан *“Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөөгүй, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг нягтлан бодогчгүй, эд хариуцагч ажиллуулдаггүйгээс дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангаар 2021 онд нийт 32,445.3 мянган төгрөгийн мөнгөн орлого, 30,646.7 мянган төгрөгийн мөнгөн зарлага, үүнээс кассаар буюу бэлэн мөнгөөр 14,295.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн болон бусад хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнийг даргын үүрэг гүйцэтгэгч Ц. Алтанцэцэг ганцаараа гүйцэтгэж, хөрөнгийг захиран зарцуулснаар хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналт алдагдсан.
- Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь *“Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1: Анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2: Журналд бичих, 14.3.3: Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4: Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5: Санхүүгийн тайлан гаргах”* гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Журнал, кассын тайлан, бараа материалын тайлан, шаардах хуудас, зарлагын баримт зэрэг анхан шатны баримтуудыг нягтлан бодогчоор хянуулдаггүй, тамга, тэмдгээр баталгаажуулдаггүй бөгөөд тайлант онд бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх, зарлагын баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 2,479.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх *“Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан*

*шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, нягтлан бодогч ажиллуулах замаар нягтлан бодох бүртгэлийг холбогдох дарааллаар хөтлөх, анхан шатны баримтыг батлагдсан маяг аргачлалын дагуу бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

## **8.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд **3,306.8** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ	СЭА-2022/02-НА-СТА-ОНА	“2021 оны зорилтот түвшин, төлөвлөгөөг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зардлын тооцоогоор нэг бүрчлэн төлөвлөөгүй,	1	-					1	-			
	“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ	СЭА-2022/02-НА-СТА-ОНА	Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн,	1	2,479.0					1	2,479.0			
4	“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ	СЭА-2022/02-НА-СТА-ОНА	Бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.	1	3,306.8								1	3,306.8
<b>ДҮН</b>				<b>3</b>	<b>5,785.8</b>					<b>2</b>	<b>2,479.0</b>			<b>1</b> <b>3,306.8</b>
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
1	“Сэлэнгэ үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ	СЭА-2022/02-НА-СТА-ОНА	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих <b>52</b> мэдээллийг хугацаа хоцроон, <b>44</b> мэдээллийг огт мэдээлээгүй.	1	-					1	-			
<b>ДҮН</b>				<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>			
<b>НИЙТ ДҮН</b>				<b>4</b>	<b>5,785.8</b>					<b>3</b>	<b>2,479.0</b>			<b>1</b> <b>3,306.8</b>